

## Хэвлэлийн мэдээ

2018 оны 4 дүгээр сарын 23

Улаанбаатар хот

### **ХҮНД НӨХЦӨЛ ДЭХ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДАЙ АЖИЛЛАХ ДАСГАЛЖУУЛАГЧ, БАГШ НАРЫГ “НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК”-ЭЭР ДАМЖУУЛАН БЭЛТГЭЖ БАЙНА**

“Нийгэмшүүлэх цирк” бол дэлхийд алдартай Канадын Нарны Цирк корпорацийн боловсруулсан 50 гаруй оронд хэрэгждэг олон улсын томоохон хөтөлбөр юм. Хүнд нөхцөл дэх хүүхэд, залуусын хувь хүний хөгжил, нийгмийн амьдралд орох үр чадварыг дэмжих зорилготой энэ хөтөлбөрийг Хүүхдийг Ивээх Сан Монгол улсад 1999 оноос хойш хэрэгжүүлж, 9000 гаруй хүүхэд болон багш нарт циркийн урлагаар дамжуулан бие бялдрын болон тулгарсан бэрхшээлийг даван туулах, нийгэмших үр чадвар, аргагүйг эзэмшүүлсэн билээ.

Хөтөлбөрийн хүрээнд Хүүхдийг Ивээх Сан 2018 оны 4 дүгээр сарын 23-наас 4 сарын 27-ны өдрүүдэд Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн газартай хамтран “Нийгэмшүүлэх цирк” хөтөлбөрийн дасгалжуулагч багш, нийгмийн ажилтнуудыг бэлтгэх сургалтыг зохион байгуулж байна. Сургалтанд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 29, 25, 55, 70 дугаар тусгай сургуулийн багш нар, “Нарт хангай” хүүхэд хамгааллын төвийн ажилтнууд, Насан түршийн боловсролын үндэсний төв, түүний харьяа Баянзүрх дүүрэг, Сүхбаатар дүүргийн Албан бус/ насан түршийн боловсролын төвийн багш нар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хамгаалах байрны ажилтнууд хамрагдаж байна.

Сургалтын үр дүн:

- Сургалтад хамрагдсан байгууллагуудын ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөл дэх хүүхэд, залуучуудтай ажиллах “Нийгэмшүүлэх цирк”-ийн аргагүйг эзэмшинэ
- Хүнд нөхцөл дэх хүүхэд залуучуудтай ажиллах шинэлэг аргазүй, арга барил бүхий хүний нөөц бэлтгэгдэнэ
- Сургалтад хамрагдсан байгууллагуудын хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих чадавхи сайжирна

**Сургалт зохион байгуулагдах хугацаа:** 2018 оны 4 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд

**Зохион байгуулагдах газар:** Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай 29 дүгээр сургуулийн “Урлаг” заал

**Дэлгэрэнгүй мэдээлэл, ярилцлага, гэрэл зургийг:**

Э.Оюунмаа, Хүүхдийг Ивээх Сан Нийгэмшүүлэх цирк төслийн ажилтан  
[oyunmaa@savethechildren.mn](mailto:oyunmaa@savethechildren.mn), Утас: +976-329365, +976-99135150

**Төслийн танилцуулга болон ном, гарын авлагыг эндээс татаж үзнэ үү.**

<https://www.savethechildren.mn/mn/page/social+circus+>

**“НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК” сургалтын хөтөлбөр**

| <b>Эхний өдөр/2018.04.23 (Даваа)</b>       |  |  |
|--|--|--|
| 08:30-09:00                                | Бүртгэл  |  |
| 09:00- 10:00                               | Танилцуулга  | <ol style="list-style-type: none"> <li>1. Сургалтын танилцуулга</li> <li>2. Танилцах дасгал</li> <li>3. Сургалтын дүрэм батлах</li> </ol>  |
| 10:00-10:30                                | <b>Засвсарлага/ Бие халаах дасгал тоглоом</b>  |  |
| 10:30- 13:00                               | <b>Хэсэг 1:</b> Нийгэмшүүлэх циркийн тухай үндсэн ойлголт                              | <ol style="list-style-type: none"> <li>1. ХИС-гийн Хүүхэд хамгааллын бодлого</li> <li>2. Нийгэмшүүлэх циркийн үүсэл, хөгжил, ач холбогдол, түүний үндсэн зарчим</li> <li>3. Идэвхижүүлэх дасгал, тоглоом (өөрөө өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх нь)</li> </ol> |
| 13:00-14:00                                | <b>Үдийн завсарлага</b>  |  |
| 14:00- 15:30                               | <b>Хэсэг 2:</b> Циркийн хэрэгсэлтэй ажиллах, техникийг заах үр чадвараа хөгжүүлэх нь   | <ol style="list-style-type: none"> <li>1. Циркийн жонглёрын төрөл түүний үнэт чанар</li> <li>2. Жонглёрын техник, хэрэгсэлүүдтэй танилцах (алчуур, бөмбөг, булавь, саваа)</li> </ol>   |
| 15:30-15:40                                | <b>Завсарлага</b>  |  |
| 15:40-17:30                                | <b>Хэсэг 2:</b> Үргэлжлэл)   | <ol style="list-style-type: none"> <li>3. Жонглёрын техникийг заах аргазүй</li> <li>4. Нийгэмшүүлэх дасгал тоглоом</li> </ol>  |
| 17:30-18:00                                | Өдрийн дүгнэлт   |  |
| <b>Хоёр дахь өдөр/ 2018.04.24 (Мягмар)</b> |  |  |
| 09:00-09:10                                | Эхний өдрийн агуулгыг сэргээх  |  |
| 09:10-09:40                                | Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих үндэсний хөтөлбөр танилцуулга                         | <ol style="list-style-type: none"> <li>1. Сургалтын албан ёсны нээлт</li> <li>2.</li> </ol>  |
| 09:40- 11:00                               | <b>Хэсэг 3:</b> Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтны үр чадвар үүрэг, ёсзүй            | <ol style="list-style-type: none"> <li>1. Дасгалжуулагч багшийн үр чадвар, үүрэг</li> <li>2. Нийгмийн ажилтны үр чадвар, үүрэг</li> <li>3. Ёсзүй</li> </ol>  |
| 11:00-11:30                                | <b>Завсарлага/Идэвхижүүлэх тоглоом</b>   |  |
| 11:30 -13:00                               | <b>Хэсэг 4:</b> Нийгэмшүүлэх цирк сургалт зохин байгуулахдаа аюулгүй байдлыг хангах нь | <ol style="list-style-type: none"> <li>1. Сургалтын тоног, төхөөрөмж, техник хэрэгсэлүүдийн аюулгүй байдал</li> <li>2. Сургалтын үеийн аюулгүй байдал</li> </ol>   |
| 13:00-14:00                                | <b>Үдийн завсарлага</b>  |  |
| 14:00 -15:00                               | <b>Хэсэг 4</b> Үргэлжлэл   | <ol style="list-style-type: none"> <li>3. Сургалтад оролцогчдын сэтгэлзүйн аюулгүй байдал</li> </ol>   |
| 15:00- 15:10                               | <b>Завсарлага</b>  |  |
| 15:10- 17:40                               | <b>Хэсэг 5:</b> Циркийн хэрэгсэлтэй ажиллах, техникийг заах үр чадвараа хөгжүүлэх нь   | <ol style="list-style-type: none"> <li>1. Циркийн тэнцвэрийн төрөл түүний үнэт чанар</li> <li>2. Тэнцвэрийн төрлийн хэрэгсэлтэй танилцах, техникийг заах аргазүй (катюшка, пирамид)</li> <li>3. Нийгэмшүүлэх дасгал тоглоом</li> </ol>                           |
| 17:40- 18:00                               | Өдрийн дүгнэлт   |  |

| <b>Гурав дахь өдөр/ 2018.04.25</b> |  |  |
|------------------------------------|--|--|
| 09:00-09:10                        | Хоёр дахь өдрийн агуулгыг сэргээх  |  |
| 09:10- 11:00                       | <b>Хэсэг 6:</b> Хүнд нөхцөл дэх хүүхэд, залуучуудтай ажиллах нь                      | <ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхдийн хөгжил</li> <li>2. Хүүхдийн насны үечлэл, хөгжлийн онцлог</li> <li>3. Хүүхдийн хөгжилд хүчирхийлэл, үл хайхрах байдал нөлөөлөх нь</li> </ol>  |
| 11:00-11:10                        | <b>Завсарлага</b>  |  |
| 11:10- 13:00                       | <b>Хэсэг 6:</b> Хүнд нөхцөл дэх хүүхэд, залуучуудтай ажиллах нь (үргэлжлэл)          | <ol style="list-style-type: none"> <li>4. Нийгэмшүүлэх цирк сургалтыг хамгааллын үйлчилгээний практикт хэрэглэх <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийг хүчирхийлэл дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлэх</li> </ul> </li> </ol> |
| 13:00 -14:00                       | <b>Үдийн завсарлага</b>  |  |
| 14:00- 15:00                       | <b>Хэсэг 6:</b> Хүнд нөхцөл дэх хүүхэд, залуучуудтай ажиллах нь (үргэлжлэл)          | <ul style="list-style-type: none"> <li>• Хамгаалал, тусламж шаардлагатай хүүхдийг илрүүлэх, үйлчилгээнд холбох</li> </ul>  |
| 15:00-15:10                        | <b>Завсарлага</b>  |  |
| 15:10-17:40                        | <b>Хэсэг 7:</b> Циркийн хэрэгсэлтэй ажиллах, техникийг заах ур чадвараа хөгжүүлэх нь | <ol style="list-style-type: none"> <li>1. Циркийн акробатын төрөл түүний үнэт чанар</li> <li>2. Акробатын төрлийн хэрэгсэлтэй танилцах, техникийг заах аргагүй (өнхрөлт, дээс, үсрэлт)</li> <li>3. Нийгэмшүүлэх дасгал, тоглоом</li> </ol> |
| 17:40-18:00                        | Өдрийн дүгнэлт   |  |
| <b>Дөрөв дэх өдөр/ 2018.04.26</b>  |  |  |
| 09:00-09:10                        | Гурав дахь өдрийн агуулгыг сэргээх   |  |
| 09:10- 11:00                       | <b>Хэсэг 8:</b> Нийгэмшүүлэх цирк сургалтыг зохион байгуулах                         | <ol style="list-style-type: none"> <li>1. Нийгэмшүүлэх цирк сургалтын аргагүйн зарчим</li> <li>2. Сургалтын бэлтгэлийг хангах нь</li> </ol>  |
| 11:00-11:10                        | <b>Завсарлага</b>  |  |
| 11:10 -13:00                       | <b>Хэсэг 8:</b> Үргэлжлэл  | <ol style="list-style-type: none"> <li>3. Сургалтын төлөвлөгөө боловсруулах</li> <li>4. Хамтран ажиллах арга барил, хослон заах аргагүй</li> </ol>   |
| 13:00-14:00                        | <b>Үдийн завсарлага</b>  |  |
| 14:00-16:00                        | <b>Хэсэг 8:</b> Үргэлжлэл)   | <ol style="list-style-type: none"> <li>5. Сургалт зохион байгуулах үйл явц</li> </ol>  |
| 16:00-16:10                        | <b>Завсарлага</b>  |  |
| 16:10-17:40                        | <b>Хэсэг 9:</b> Циркийн хэрэгсэлтэй ажиллах, техникийг заах ур чадвараа хөгжүүлэх нь | <ol style="list-style-type: none"> <li>1. Бие халаах, сунгалт, хүчний дасгал түүний үнэт чанар</li> <li>2. Бие халаах дасгалуудыг заах аргагүй</li> </ol>  |
| 17:40-18:00                        | Өдрийн дүгнэлт   |  |
| <b>Тав дахь өдөр/ 2018.04.26</b>   |  |  |
| 09:00-09:10                        | Өмнөх өдрийн сургалтын агуулгыг сэргээх  |  |

|               |  |  |
|---------------|--|--|
| 09:10-11:00   | <b>Хэсэг 10:</b> Сургалтад оролцогч хүүхдүүдэд гарч буй өөрчлөлтийг үнэлэх           | <ol style="list-style-type: none"> <li>1. Бие махбодын чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах аргачлал</li> <li>2. Нийгэмшлийг үнэлэх аргачлал</li> </ol> |
| 11:00 -11:10  | <b>Завсарлага</b>  |  |
| 11:10-13:00   | <b>Хэсэг 11:</b> Сургалтаар хүүхдүүдэд бэрхшээлийг даван туулах чадварыг төлөвшүүлэх | <ol style="list-style-type: none"> <li>1. Ээнэгшлийн харилцаа</li> <li>2. Бэрхшээлийг даван туулах чадвар</li> </ol>                                       |
| 13:00-14:00   | <b>Үдийн завсарлага</b>  |  |
| 14:00- 16:00  | <b>Хэсэг 12:</b> Суралцагчдын бүтээлч байдал, хошин шогийн мэдрэмжийг хөгжүүлэх      | <ol style="list-style-type: none"> <li>1. Дасгал, тоглоом</li> <li>2. Нийгэмшүүлэх дасгал тоглоом</li> </ol>   |
| 16:00-16:10   | <b>Завсарлага</b>  |  |
| 16:10- 16: 50 | Циркийн хэрэгсэлийг гарын доорхи материал ашиглан хийх аргачлал                      | <ol style="list-style-type: none"> <li>1. Жонглёрын бөмбөг</li> <li>2. Булавь</li> <li>3. Цагираг</li> </ol>   |
| 16:50-17:30   | Сургалтын хаалт  | <ol style="list-style-type: none"> <li>1. Дүгнэлт ярилцлага, үнэлгээ</li> <li>2. Гэрчилгээ гардуулах</li> </ol>  |